

# НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянгол дүүргийн Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/277/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга	Ч.Болд
	Утас: 7000-7734	Цахим хаяг: <a href="mailto:boldch@audit.gov.mn">boldch@audit.gov.mn</a>
	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга	Х.Түвшинбаяр
	Утас: 315558	Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>
	Аудитын менежер:	С.Гантөгс
	Утас: 325093	Цахим хаяг: <a href="mailto:gantugss@audit.gov.mn">gantugss@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор:	Н.Энхмэнд
	Утас:	Цахим хаяг: <a href="mailto:enkhmendn@audit.gov.mn">enkhmendn@audit.gov.mn</a>
	Аудитор:	Б.Ариунзаяа
		Цахим хаяг: <a href="mailto:ariunzayaba@audit.gov.mn">ariunzayaba@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.24 № 01/100  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ  
ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН  
ГАЗРЫН ТАМГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА О.ГАНБАДРАХ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Баянгол дүүргийн Прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь Нийслэлийн Баянгол дүүргийн Прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Улсын ерөнхий прокурорын газрын Олон нийттэй харилцах алба болон мэргэжлийн байгууллагын туслалцаатайгаар байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 19,554.0 мянган төгрөгийн сургалтын и-контент, видео танилцуулга, шторкийг бэлтгэн, цахим хэрэгслээр нийтэд түгээж, 153,226 иргэн үзсэн хандалттай байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлд тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий удирдлагын шийдвэр, ажил гүйлгээ, үйл явдал үүсээгүй болно.

02023496

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, бүрэн хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/мянган төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	69,213.29	130,335.17
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	608,343.02	6,225,657.74
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	677,556.31	6,355,992.91
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	13,689.00	7,189.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	663,867.31	6,348,803.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	677,556.31	6,355,992.91

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,482,882.69	10,132,911.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,433.09	5,833,178.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,423,449.60	4,299,732.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,590,433.03	4,429,886.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(107,550.34)	5,703,024.64
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(7,181.14)	(18,088.04)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(114,731.48)	5,684,936.60

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,423,449.60	4,299,732.50
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,415,354.90	4,306,232.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,094.70	(6,500.00)
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(7,994.70)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	100.00	(6,500.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,689.00	13,689.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,689.00	7,189.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Буцад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,649.58	-	409,217.73	-	663,867.31
Тайлант үеийн үр дүн	-	-	5,684,936.60	-	5,684,936.60
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,649.58	-	6,094,154.33	-	6,348,803.90

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,289,732.50	4,020,022.10	269,710.40	93.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,289,732.50	4,020,022.10	269,710.40	93.7
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,289,732.50	4,020,022.10	269,710.40	93.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,289,732.50	4,020,022.10	269,710.40	93.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,289,732.50	4,020,022.10	269,710.40	93.7

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,000.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Нийслэлийн Баянгол дүүргийн Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 547.4 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 547.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 1 зөвлөмж өглөө.

### 4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд авлага дутуу тайлагнасан байна.	1	547.4	1	547.4			1	547.4				
<b>Нийт</b>	<b>1</b>	<b>547.4</b>	<b>1</b>	<b>547.4</b>			<b>1</b>	<b>547.4</b>				

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын тайланд нийт цалин хөлсийг илүү тооцон төлснөөс авлага үүсгэсэн.	1	547.4					1	547.4				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>547.4</b>					<b>1</b>	<b>547.4</b>				

#### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй.	1	15,985.0					1	15,985.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>15,985.0</b>					<b>1</b>	<b>15,985.0</b>				

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			